

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/16.

Арвайхээр

Хуваарь, чиг үүрэг батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 -ийг үндэслэн  
ТУШААХ нь:

1. Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг эрсдэлгүй, шуурхай хүргэх үүднээс сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдэд хариуцуулж, ажиллах хуваарийг нэгдүгээр, ажиллах ажлын чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хуваарийн дагуу хариуцсан сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг холбогдох эмч мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 22-ний өдрийн “Хуваарь, чиг үүрэг батлах тухай” А/31 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 04 дүгээр сарын 28  
өдрийн 4/16 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ, СУМ,  
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙГ ХАРИУЦАН  
АЖИЛЛАХ ЭМГ-ЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХУВААРЬ

д/д	Овог нэр	Албан тушаал	Хариуцан ажиллах нэгж байгууллага
1	Н.Оюунтуяа	Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга	Хархорин сумын нэгдсэн эмнэлэг
2	Ю.Ичинноров	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
3	М.Золзаяа	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга	Есөнзүйл сумын эрүүл мэндийн төв
4	Я.Жаргал	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга	Уянга сумын эрүүл мэндийн төв, Жаргалан багийн эмнэлэг
5	С.Дуламсүрэн	Нөхөн үржихүй, өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	Бат-Өлзий сумын эрүүл мэндийн төв
6	Б.Ариунзаяат	Хүүхдийн тусламж үйлчилгээ, магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	Баруунбаян-Улаан сумын эрүүл мэндийн төв
7	Б.Баттуяа	Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	Өлзийт сумын эрүүл мэндийн төв
8	Ч.Одончимэг	Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж хариуцсан мэргэжилтэн	Сант сумын эрүүл мэндийн төв
9	Ц.Сонинбаяр	Халдварт бус өвчний эрт илрүүлэлт, осол гэмтэл, хүчирхийлэл, сэтгэцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Нарийнтээл сумын эрүүл мэндийн төв, Баянтээг багийн эмнэлэг
10	М.Ганцэцэг	Халдварт өвчин, бэлгийн зам, эмнэлгээс шалтгаалах, цусаар дамжих болон гэдэсний халдварын тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн	Баянгол сумын эрүүл мэндийн төв
11	Д.Нацагням	Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	Зүүнбаян-Улаан сумын эрүүл мэндийн төв

12	Н.Отгонбаяр	Сум, өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, яаралтай тусламж, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Богд сумын эрүүл мэндийн төв
13	Ц.Рэгзэдмаа	Гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, ахмад настны эрүүл мэнд, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Баян-Өндөр сумын эрүүл мэндийн төв
14	Б.Оюунчимэг	Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	Тарагт сумын эрүүл мэндийн төв
15	Н.Амаржаргал	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Төгрөг сумын эрүүл мэндийн төв
16	Т.Номин	Эмийн чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн	Хайрхандулаан сумын эрүүл мэндийн төв
17	С.Энхцэцэг	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Гучин-Ус сумын эрүүл мэндийн төв
18	Р.Уранчимэг	Статистик мэдээллийн ажилтан	Бүрд сумын эрүүл мэндийн төв
19	Н.Төгс-Очир	Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	Хужирт сумын эрүүл мэндийн төв
20	Ж.Болзол	Хууль эрх зүй, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төв
21	Б.Долзодмаа	Халдварт өвчин, дархлаажуулалтын мэдээ, мэдээлэл хүйтэн хэлхээ хариуцсан ажилтан	Түшигдөлгөөн өрхийн эрүүл мэндийн төв
22	Э.Лхагвадулам	Халдварт өвчин, амьсгалын замын халдвар, сүрьеэ, зоонозын халдварын асуудал хариуцсан мэргэжилтэн	Уянсэтгэл өрхийн эрүүл мэндийн төв
23	Э.Даваадорж	Халдварт бус өвчин, нийтийн биеийн тамир, архи, тамхины хэрэглээг бууруулах, хүн амын зохистой хооллолтын асуудал хариуцсан мэргэжилтэн	Энэрэл хархорин өрхийн эрүүл мэндийн төв



Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 04 дүгээр сарын 28  
өдрийн 416 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ ХАРИУЦСАН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН  
АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

- Эрүүл мэндийн газар болон бусад байгууллагаас хүргүүлсэн хариутай бичиг болон мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь ирүүлэх чиг үүрэг өгч ажиллах;
- Цаг үеийн нөхцөл байдлаас хамаарсан яаралтай зар, мэдээллийг хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвд утсаар шуурхай хүргэж, байгууллагын удирдлага, холбогдох хэлтэс албанд эргэн мэдээлэх;
- Эрүүл мэндийн салбараас гарч буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тушаал, шийдвэр, тухайлсан жил, онцлох үйл ажиллагаа, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөрдөгдөж буй стандарт, удирдамж, зааврын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үнэлгээ, дүгнэлт хийж, мэргэжил арга зүйгээр хангах;
- Цаг уурын таагүй нөхцөл байдал /ган, зуд, үер/ үүсэх, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчин дэгдэлтээр гарах зэрэг гамшиг, онцгой байдлын үед хүн амын ялангуяа эх хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зөвлөмжөөр хангаж, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;
- Хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр тулгамдаж буй асуудлыг тухайн сум, өрхийг хариуцсан эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн эмч нартай хамтран тодорхойлж, шийдвэрлэх ажлын саналыг сумын Засаг дарга болон Эрүүл мэндийн газар, БОЭТ-ийн удирдлагад тавьж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулах, мэргэжлийн зэрэг хамгаалуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх асуудлыг сум орон нутгийн болон Эрүүл мэндийн газрын удирдлага, холбогдох нийгэмлэг холбоодод уламжилж шийдвэрлүүлэх;
- БОЭТ болон төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлгүүдэд ажлын байранд сэлгүүлэн ажиллуулах, дагалдан сургалтанд хамруулах;

- Эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмж, ялангуяа эх, хүүхдэд үзүүлж буй тусламжийг сайжруулах чиглэлээр тухайн сумдад зөвлөмж хүргэх;
- Тухайн сум, орон нутгаас гаргасан хүсэлтийн дагуу ажлын байранд зөвлөн туслах, сургалт явуулах зэрэг шинэлэг үйл ажиллагааг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах;

--oOo--